



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокурорын газрын харьяа Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 22,000,000.00 (хорин хоёр сая) төгрөгийн балансын үнэ, 14,666,666.72 (арван дөрвөн сая зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг далан хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий Ниссан патрол маркийн автомашиныг хавсралтад заасны дагуу Ховд аймаг дахь Хөгжил политехник коллежид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Улсын ерөнхий прокурорын газрын Туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Прокурорын газрын Ерөнхий прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Г.Батбаяр, Ховд аймаг дахь Хөгжил политехник коллежийн захирал Д.Баярмаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
123007575
1-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 08 дугаар сарын 11-өдрийн
1/2 дугаар тогтоолын хавсралт

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН
ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ниссан патрул, улсын дугаар 08-00 ДГО, арлын дугаар JN1TCSY61Z0580931	2011/2011	22,000,000.00	14,666,666.72	7,333,333.28
Нийт дүн			22,000,000.00 (хорин хоёр сая)	14,666,666.72 (арван дөрвөн сая зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг далан хоёр мөнгө)	7,333,333.28 (арван дөрвөн сая зургаан зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг далан хоёр мөнгө)